

15

САНХҮҮ-ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ

(Орхон аймгийн эрчим хүч, дулаан үйлдвэрлэлт, усан хангамжийн
салбарын жшиээн дээр)

Л.Баасандорж

Удиртгал

Аливаа бизнесийн байгууллагын тогтвортой оршин тогтнох үндэс нь тухайн байгууллага санхүүгийн чадавхи сайн байх явдал юм. Өөрөө хэлбэл, бизнесийн байгууллагыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт гэж болно. Санхүүгийн чадавхи нь тухайн байгууллагын төдийгүй тухайн салбарын эдийн засгийн өсөлт, хөгжилд нөлөөлөгч гол хүчин зүйл болох юм.

Санхүүгийн чадавхи гэдэг нь хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй, эдийн засаг-санхүү зээлийн системүүдтэй нягт холбогдсон, хөрөнгийн зах зээлд идэвхитэй оролцдог, санхүүгийн үйл ажиллагаа нь харьцангуй тогтворжсон, санхүүгийн хэрэгслүүдийг чадварлагаар хослуулан ашиглах болон санхүүгийн үүрэг хариуцлага хүлээх чадвар юм. (МУИС.Эдийн засгийн сургууль “Монгол улс зах зээлд” Улаанбаатар. 2007 он, 375-р тал)

Бизнесийн байгууллагууд практикт санхүүгийн чадавхийг үнэлж дүгнэхдээ:

1. Хөрөнгө, капиталын бүтэц бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ
2. Төлбөрийн чадварын шинжилгээ
3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ
4. Хөрөнгө, капиталын ашиглалт, эргэцийн шинжилгээ
5. Ашигт ажиллагааны шинжилгээ гэсэн үзүүлэлтүүдийн системээр судлан шинжилж, үнэлэлт, дүгнэлт өгч байна.

Энэхүү судалгааг хийхдээ Орхон аймагт цахилгаан, дулаан үйлдвэрлэл ба түгээлт, усан хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагуудын 2004-2009 оны санхүүгийн тайлангийн

тоон үзүүлэлтүүдийг ашиглан санхүү-эдийн засгийн шинжилгээний арга аргачлалын дагуу судалгаа шинжилгээг хийж салбарын санхүүгийн чадавхид үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорилоо.


Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт ба түгээлт, усан хангамжийн салбарын макро эдийн засгийн байдалд хийсэн судалгаа

Өнөө үед улс орны эдийн засгийн хөгжил нь нэгтгалаас, эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ, түүний өсөлтөөс шууд хамаарах ба хүн ам өсч, соёл иргэншил хөгжихийн хирээр эрчим хүчний хэрэгцээ улам нэмэгдэх бөгөөд эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ, түүнийг үр ашигтай хэрэглэх технологийн түвшин, эдийн засгийн хөгжлийн хурдацыг хангаж чадахгүй, удаашралтай явагдвал бэрхшээл тулгарах нь зайлшгүй болж, дэлхий дахинд өргөн хэрэглэж буй уламжлалт аргаар гаргаж байгаа эрчмийн үйлдвэрлэл нэмэгдэх тутам, түүнд зориулагддаг түүхий эдийн нөөц хомсдож, үүний үр дүнд бүтээгдэхүүний өртөг улам бүр өсөхийн хамт хүрээлэн байгаа орчны бохирдолт ихэсдэг нь өнөөдөр дэлхийн нийтийн төдийгүй манай орны тулгамдсан асуудал болж байгаа тул энэ талаар дэлхий дахинд олон улсын хэмжээнд гаргасан шийдвэрүүдэд манай улс нэгдэн орлоо. Тухайлбал 1992 оны РиоДеЖанеро хотод болсон НҮБ-ын дээд хэмжээний уулзалт, 1997 оны Киотогийн протокол зэргийг дурдаж олно.

1990-ээд оноос салбарын хөгжлийг олон улсын хөгжил дэвшилтэй уялдуулах зорилгоор “Дэлхийн эрчим хүчний Зөвлөл”, “Европын эрчим хүчний харти”-д гишүүнээр элсэн орсон ба Төв Ази, Зүүн хойд Азийн хамтын ажиллагаа, “Ази номхон далайн эдийн засаг нийгмийн комисс”, “Их Түмэн санаачлага” зэрэг олон улс, бүс нутгийг хамарсан эрчим хүчний олон талт хамтын ажиллагаа, хоёр хөрш орнууд болон гуравдагч орнуудтай хийж байгаа хоёр талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцон салбарыг хөгжүүлэх олон улсын хамтын ажиллагааны эхлэл суурийг тавьж, хөгжүүлсэн, мөн түүнчлэн улсын төсөв, гадаадын зээл тусламж, орон нутаг болон байгууллагын өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор хийж байгаа нь нийгмийн шаардлага, салбарын хөгжил төр хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх эхлэл суурийг тавьсан үе болж байна.

Өнөөдрийн байдлаар манай улсын эрчим хүчний нөөцийн ашиглалтын байдал нь доорх байдалтай байна.


Диаграмм №1



2009 онд эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч томоохон 18 компани 8702 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулан 360 гаруй мянган хэрэглэгчдийг цахилгаан, дулаанаар хангаж ажилласан байна.

Салбарын ажиллагсдын 2005-2009 оны статистик үзүүлэлтийг графикаар харуулбал:

График №1 (мян.хүн)



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ 2009 он

Дээрх графикаас харахад салбарт ажиллаж буй ажиллах хүч нь улсын нийт ажиллах хүчний дундажаар 2,67%-ийг эзэлж байгаа нь харагдаж байна. 2005 оноос салбарт ажиллах ажиллах хүчний тоо 2007 он гэхэд 9,1%-аар өссөн байсан нь сүүлийн 5 жилд гарсан хамгийн өндөр үзүүлэлт болж байсан бол 2009 онд ажиллах хүчний тоо 2005 онтой харьцуулахад даруй 45,3%-аар буурсан байна. Энэ нь ажиллах хүчний судалгааг 2009 оноос шинэчилсэн аргачлалын дагуу бэлтгэдэг болсонтой холбоотойгоор бусад салбарт зарим ажиллагсдын тоо нэгтгэгджээ.

Орхон аймагт цахилгаан, дулаан үйлдвэрлэлт ба түгээлт, усан хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэт ДЦС” ТӨХК, “ЭБЦТС” ОНӨХК, “Эрдэнэт Амьдрал” ХХК, “Эрдэнэт Ус” ОНӨХК, Төвийн

бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний Эрдэнэт-Хархорины салбар, УБҮ “Эрдэнэт” ХХК-ний ДЦС, “Жаргалант Илч” ХХК зэрэг байгууллагууд байна.

Орхон аймаг болон хангайн бүсийн хувьд нийт болон салбарт ажиллах хүчний тоон үзүүлэлт нь 2005-2009 оны дүнгээр доорх байдалтай байна.

Хүснэгт №1 (мян.хүн)					
Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009
Хангайн бүсийн нийт ажиллах хүч	227,6	234,9	238,9	238,5	236,6
Орхон аймгийн нийт ажиллах хүч	33,5	33,9	32,6	32,7	29,2
Орхон аймгийн салбарын ажиллах хүч	1,125	1,128	1,130	1,012	1,017


Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ 2009 он

Орхон аймгийн хэмжээндуг салбарт ажиллах хүчний тоо сүүлийн жилүүдэд 1,4%-аар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ салбарт ажиллагсад нь дундажаар бүсийн нийт ажиллах хүчний 0,46%, аймгийн нийт ажиллах хүчний 3,34%-ийг эзэлж байна.

Сүүлийн 2005-2009 онуудын байдлаарх салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт болон борлуулалтын хэмжээг аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалттай харьцуулан авч үзвэл доорх байдалтай байна.

Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жилд дундажаар 25,2%-аар өссөн бөгөөд үүнийг дагаад салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жилд дундажаар 18,3 %-аар өссөн байна.

График №2 (сая. төг-өөр)



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ 2009 он

Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг бүтээгдэхүүн тус бүрээр харуулбал доорх байдалтай байна.

Хүснэгт №2

Үзүүлэлтүүд	2005	2006	2007	2008	2009
Цахилгаанэрчимхүч (сая.кв.цаг)	3 418,90	3 544,20	3 700,70	4 000,60	4 038,80
Дулааныэрчимхүч (мян. Гкал)	7 805,60	7 850,40	7 723,50	7 759,60	8 320,50
Түгээсэнус (сая.м.куб)	62,30	60,10	64,70	65,40	63,30

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ 2009 он

Харин салбарын бүтээгдэхүүн борлуулалтын хэмжээ нийт аж үйлдвэрийн салбарийн хувьд өссөөр байгаа боловч цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлтийн салбарын хувьд 2005-2007 онуудад өсч байгаад сүүлийн жилүүдэд буюу 2008 онд өмнөх оны мөн үеэс 2,2%-аар, 2009 онд өмнөх оноосоо даруй 21.4%-аар буурсан үзүүлэлт гарсан байна. Гэхдээ эрчим хүчний төв, баруун, зүүн бүсийн системийн дүнгээр 2009 онд дулааны цахилгаан станцаар 3,989,7 сая кВт.ц усан станцаар 11,05 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, импортоор 180,8 сая кВт.ц цахилгаан худалдан авч, экспортод 21,2 сая кВт.ц цахилгаан гарган, 2746,9 сая кВт.ц цахилгаан, 6,399,7 мян.Гкал дулаан хэрэглэгчдэд түгээсэн байна. Өөрөөр хэлбэл, 2005-2009 онуудад салбарын нийт борлуулалт дундажаар 16,39%-аар өссөн үзүүлэлттэй байна.

График №3 (сая. төг-өөр)



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ 2009 он

Орхон аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд үйлдвэрлэсэн болон борлуулсан цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарын үзүүлэлтийг авч үзвэл:


Хүснэгт №3 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үзүүлэлтүүд	2004	2005	2006	2007	2008
Цахилгаан эрчим хүч (мян.кв.цаг)	103,2	106,7	108,4	110,0	113,6
Дулааны эрчим хүч (мян. Гкал)	608,5	575,0	581,4	648,3	618,6

Хүснэгтээс харвал цахилгааны эрчим хүч үйлдвэрлэлт жилд дундажаар 108,38 мян.кв.цаг буюу жилийн дундаж өсөлт 2,4% байхад дулааны эрчим хүч үйлдвэрлэлт жилд дундажаар 606,36 мян.Гкал буюу жилийн дундаж өсөлт 0,4% байна.

2006-2008 оны Орхон аймгийн хэмжээгээрх салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт борлуулалтыг графикаар харуулбал доорх байдалтай байна.

График №4 (сая. төг-өөр)



Эх сурвалж: Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

“Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжил (2004-2008)”. Эрдэнэт хот. 2009 он

Эндээс харахад салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт аймгийн дүнгээр 2008 оныг 2007 онтой харьцуулахад 30,3%-аар, бүтээгдэхүүн борлуулалт 28,3%-аар тус тус өссөн үзүүлэлт харагдаж байна.

Харин улсын дүнгээр эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд 2009 онд нийт 237,9 тэрбум төгрөгний үйл ажиллагааны орлого олж, 275 тэрбум төгрөгний зардал гарган үндсэн үйл ажиллагаанаас 37,1 тэрбум төгрөгний алдагдалтай ажилласан ба татварын дараах балансын алдагдал 69,6 тэрбум төгрөгт хүрсэн.

Жилд дунджаар 7000 орчим үндсэн ба туслах тоноглолд 18.9 тэрбум төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэж, 3.5 тэрбум төгрөгийн техник зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Эрчим хүчний салбар зохицуулалтанд орсноор эрчим хүчний үнэ тарифт өнгөрсөн хугацаанд 5-н удаа зохицуулалт (2002, 2005, 2007, 2008,

2009 онд) хийсний үр дүнд борлуулалтын орлого 2001 онд 96.0 тэрбум төгрөг байсан бол 2009 онд 237.0 тэрбум төгрөг буюу орлого 2.5 дахин нэмэгджээ.

Эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийгдсэн 2001 оноос хойшхи 8 жилийн хугацаанд хэрэглэгчдэд борлуулах цахилгаан, дулааны үнэ тарифт 20 удаа, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тарифт 152 удаа тус тус зохицуулалт хийгдсэн. Үүний үр дүнд Төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны үнэ 2001 оны эцэст байснаас 1.5 дахин, орон сууцны халаалтын тариф 1.65 дахин, ахуйн хэрэгцээний халуун усны тариф 2,5-3,75 дахин нэмэгдэж, эрчим хүчний томоохон 18 компанийн үйл ажиллагааны борлуулалтын орлого 2001 онтой харьцуулахад 142,0 тэрбум төгрөгөөр буюу 2.5 дахин нэмэгдсэн байна.

Цахилгаан, дулааны хэрэглээний өсөлт болон хэрэглэгчдийн тарифын өсөлтөөр тусгай зөвшөөрөл эзэмшигч томоохон 18 компанийн борлуулалтын орлого 2001 онд 96,0 тэрбум төгрөг байсан бол 2009 онд 237,9 тэрбум төгрөгт хүрч, компаниудын борлуулалтын орлогын жилийн дундаж өсөлт 16,6 хувь байна. Ингэснээр компаниудын эдийн засгийн чадавхи тодорхой түвшинд дээшилсэн билээ.

Цахилгааны бөөний худалдаанд “Нэг худалдан авагчтай загвар”-ыг 2002 оноос эхлэн мөрдүүлж ажилласнаар борлуулалтын орлого төвлөрүүлэлт 70 гаруй хувьтай байсныг 2007 онд 100 хувьд хүргэж эрчим хүчний үйлдвэрүүдийг хөрөнгө мөнгөний гачаалаас гаргах, санхүүгийн чадавхийг нь дээшлүүлэхэд тодорхой үр дүнд хүрсэн.

Сүүлийн 5 жилийн дундажаар ДНБ үйлдвэрлэлийн 2,36%-ийг энэ салбар бүрдүүлж байсан бөгөөд сүүлийн жилд даруй 0,4 пунктаар, жилд дундажаар 15,9%-аар өссөн зэрэг үзүүлэлтүүд нь санхүүгийн чадавхи дээшилж байгааг харуулж байна.

Хүснэгт №4

Үзүүлэлтүүд	2005	2006	2007	2008	2009
ДНБ, сая төг	2779598,3	3714952,9	4599541,5	6130325,5	6055794,3
Нэг хүнд ногдох ДНБ, мян төг	1091,0	1440,7	1758,9	2263,7	2234,5
Салбарын дүнгээр	80021,1	95076,1	102278,6	129805,7	144222,6
ДНБ-ний салбарын бүтэц %	3,2	2,8	2,5	2,4	2,8

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ 2009 он

Эрчим хүчний салбарт эрчим хүчний алдагдлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, тасалдал саатлыг бууруулахад чиглэгдсэн олон төсөл үр дүнтэй хэрэгжсэнээр үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааны түвшин эрс сайжирч, салбарын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ерөнхий дүр зураг харагдаж байгаа хэдий ч компаниудын санхүүгийн чадавхи суларч улмаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хандлага бий болсон байна. Эрчим

хүчний найдвартай ажиллагааг хангах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөлт давхцаж байгаа нь компаниудын санхүүгийн чадавхид ч нөлөөлж эхэллээ.

Эрчим хүчний салбар зохицуулалтад орж олон нааштай эерэг үр дүн гарч байгаагийн зэрэгцээгээр бүтцийн өөрчлөлт хийгдэхээс өмнө болон түүнээс хойш ч шийдвэрлэж чадахгүй байгаа нэг томоохон асуудал нь салбарын өр, авлагын сүлжээ юм. Эрчим хүчний үйлдвэр, уурхай, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгчийн хоорондын өр, авлагын хэмжээ дорвитой буурахгүй байгаагаас компаниуд хөрөнгийн эх үүсвэрийн хомсдолд орж санхүүгийн хувьд хүндрэлтэй байдалд байна.

Компаниудын өр төлбөр 2002 оны эцэст 43,9 тэрбум төгрөг, авлага 22,7 тэрбум төгрөг байсан бол 2009 оны байдлаар эрчим хүчний томоохон 18 компанийн бусдаас авах авлага 30,7 тэрбум төгрөг, бусдад төлөх өр төлбөр 52,8 тэрбум төгрөг болсон байна.

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт ба түгээлт, усан хангамжийн салбарын санхүүгийн тайланд хийсэн судалгаа (Орхон аймгийн үзүүлэлтээр)

Орхон аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн 3 салбар, 15 дэд салбарын нийт 130 гаруй нэгж, иргэд үйлдвэрлэл эрхлэн нийгэм, хүн амын хэрэгцээг ханган ажиллаж байна. Эдгээр салбарын нэг нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт ба түгээлт, усан хангамжийн салбар юм. Энэ салбарт одоогоор үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэт ДЦС” ТӨХК, “ЭБЦТС” ОНӨХК, “Эрдэнэт Амьдрал” ХХК, “Эрдэнэт Ус” ОНӨХК, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний Эрдэнэт-Хархорины салбар, УБҮ “Эрдэнэт” ХХК-ний ДЦС, “Жаргалант Илч” ХХК зэрэг байгууллагууд байна. Эдгээр байгууллагуудын 2004-2009 онуудын санхүүгийн тайланд шинжилгээ хийж, аймгийн хэмжээнд тухайн салбарын санхүүгийн чадавхи ямар түвшинд байгаад үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилоо.

Үүнд:

1. Хөрөнгө, капиталын бүтэц бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ

Аливаа байгууллагын хөрөнгө болон хөрөнгийн санхүүжилтийн зохистой байдал нь тухайн байгууллагын санхүүгийн чадавхийг тодорхойлох үзүүлэлтийн нэг чухал үзүүлэлт болдог. Орхон аймгийн хэмжээнд цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт ба түгээлт, усан хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын 2004-2009 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс хөрөнгө, капиталын бүтэц бүрэлдэхүүнийг доорх хүснэгтээр нэгтгэн харууллаа.

Хүснэгт №5

Балансынүзүүлэлт(хувиар)	2004	2005	2006	2007	2008	2009	Дундаж
Эргэлтийн хөрөнгө	13,62	10,66	12,40	13,66	10,79	9,77	11,82
Эргэлтийн бус хөрөнгө	86,38	89,34	87,60	86,34	89,21	90,23	88,18
Нийт хөрөнгө	100,00	100,00	100,00	100,00	100,00	100,00	100,00
Богино хугацаат өр төлбөр	10,19	9,42	11,36	12,38	10,83	11,67	10,97
Урт хугацаат өр төлбөр	1,59	1,04	1,14	1,00	0,47	0,52	0,96
Нийт өр төлбөр	11,78	10,46	12,50	13,38	11,29	12,20	11,93
Эзэмшигчийн өмч	88,22	89,54	87,50	86,62	88,71	87,80	88,07
Нийт эх үүсвэр	100,00	100,00	100,00	100,00	100,00	100,00	100,00

Дээрх хүснэгтээс харахад 2004-2009 оны дундаж үзүүлэлтээр салбарын нийт хөрөнгийн 11,82%-ийг эргэлтийн хөрөнгө, 88,18%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Хөрөнгийн бүтцэд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин өндөр байгаа нь тухайн салбарын хувьдхөрөнгийн хөрвөх чадвар удааширч, элэгдлийн зардлыг өсгөх сөрөг хандлагыг бий болгох тул салбарын хөрөнгө оруулалтын бодлого, шинэчлэлт, санхүүгийн менежментийн зөв бодлогыг хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна. Гэхдээ тухайн салбарын хувьд нийт хөрөнгийн дүнд эзлэх эргэлтийн бус хөрөнгийн хувийн жин их байх ерөнхий хандлага байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд хөрөнгийн бүтцийн хувьд 2004-2009 онуудад эргэлтийн хөрөнгийн дундаж өсөлтийн хурд -6,42% байсан бол эргэлтийн бус хөрөнгийн хувьд дундаж өсөлтийн хурд +0,87% байна. Энэхүү өсөлтөнд тухайн салбарт шинээр оруулж буй техник технологийн хөрөнгө оруулалт болон сүүлийн жилүүдэд төрийн болон төрийн өмчит бүх аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийг 2 ч удаа дахин үнэлсэн нь нөлөөлжээ. Мөн түүнчлэн манай улсын хувьд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн нийт хөрөнгийн 75-85%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлдэг гэсэн судалгаа байдаг бөгөөд Орхон аймагт энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудаас “Жаргалант илч” ХХК-аас бусад нь бүгд төрийн болон орон нутгийн өмчит компаниуд байна.

Байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж байх үзүүлэлтийн нэг нь эргэлтийн хөрөнгийн хүрэлцээ, хангамжийн асуудал байдаг бөгөөд энэ үүднээс салбарын үзүүлэлтийг тайлбарлан авч үзвэл эргэлтийн хөрөнгийн балансын бүтцэд эзлэх хувийн жин бага байгаа буюу ялангуяа 2008-2009 онуудад эргэлтийн хөрөнгө салбарын дундаж үзүүлэлтээс 1,03-2,04 пунктээр буурсан, 2004-2009 онуудад дундаж өсөлтийн хурд -6,42% байгаа зэрэг тааламжгүй үр дүн ажиглагдаж байна. Энэ нь салбарын хувьд хөрөнгийн хөрвөх чадварыг бууруулж, үүнээс үүдэн гарах эрсдлийг улам бүр нэмэгдүүлэх хандлагыг бий болгож байгаа ч нөгөө талаас энэхүү эргэлтийн хөрөнгийн рестриктбодлого нь үйлвэрлэлийн үндсэн хүчин зүйл болох үндсэн хөрөнгийг боломжит дээд хэмжээнд байлгаж үйлдвэрлийн хүчин чадал, нөөцөө бүрэн хэмжээгээр дайчласнаар салбарын ашигт ажиллагааг нэмэгдүүлж болох сайн талтай байж болох юм. Гэхдээ салбарын хувьд төлбөрийн чадварыг

нэмэгдүүлэх, хөрөнгийн бүтцэд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувийн жинг өсгөх зэрэг эргэлтийн хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалтын бодлого, ажлын капиталын менежмент хэрэгтэй байгаад анхаарал хандуулах хэрэгтэй юм.

Харин хөрөнгийн санхүүжилтийн бүтцийн хувьд 2004-2009 оны дундаж үзүүлэлтээр салбарын нийт хөрөнгийн эх үүсвэрийн 11,93-ийг гадны эх үүсвэрээр, 88,07%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байгаа нь харагдаж байна. 2004-2009 онуудад гадны капиталын дундаж өсөлтийн хурд +0,70% байсан бол өөрийн капиталын дундаж өсөлтийн хурд -0,09% байна. Нийт хөрөнгийн бараг 90% хувийг өөрийн капиталаар санхүүжүүлж байгаа нь салбарын санхүүгийн хувьд бие даах чадвар өндөр байгааг илтгэн харуулж байна. Салбарын хувьд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд нь төрийн болон орон нутгийн өмчөөр өөрийн хөрөнгийн дийлэнх хувийг бүрдүүлж байдаг төдийгүй манай улсын энэ салбарт авч хэрэгжүүлж байдаг үнэ тарифын бодлогын зохицуулалтаас болж алдагдалтай ажилладаг. Түүнчлэн өөрийн хөрөнгийн дүнд дахин үнэлгээний нэмэгдлийн эзлэх хувь сүүлийн жилүүдэд тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна. Олон жилийн хуримтлагдсан алдагдал нь өмчийн бусад үзүүлэлтээр нөхөгдөж байгаа хэдий ч салбарыг алдагдлаас ангижруулах бодлогыг төр засгийн зүгээс авч хэрэгжүүлэх шаардлага зайлшгүй урган гарч байна. Энэхүү олон жилийн хуримтлагдсан алдагдал нь компаний хувьд “тайлангийн хөндүүр зүйл анги” болдог.

Гадны капиталын бүтцэд богино хугацаат өр төлбөрийн эзлэх хувь 91,97%-ийг, урт хугацаат өр төлбөр 8,03%-ийг эзэлж байна. Энэ салбарын санхүүжилтийн бодлогод тодорхой хэмжээгээр төрийн зүгээс зохицуулалт хийгдэж байдаг тул урт хугацаат өр төлбөрийн оролцоо бага байдаг гэж дүгнэж болох талтай ч компаниуд эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэнд хямд өртөгтэй урт хугацаат гадны капиталыг тодорхой хэмжээгээр дайчилж байх нь төлбөрийн чадварыг дээшлүүлэхэд ач холбогдолтой.

Санхүүгийн чадавхийн хувьд тогтвортой байхын тулд өөрийн хөрөнгийн оролцоо их байх нь зүйтэй ч гадны капиталыг оновчтойгоор ашиглаж чадвал энэ үзүүлэлтэнд эерэг нөлөө үзүүлнэ. 2004-2009 оны дундаж үзүүлэлтээр салбарын хувьд богино хугацаат өр төлбөрийг барагдуулж чадах эргэлтийн хөрөнгийн нөөц бий нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа ч сүүлийн 2 жилд энэ үзүүлэлт сөрөг дүнтэй гарч байгаа нь төлбөрийн чадвар тодорхой хэмжээнд суларч байгааг илтгэж байна. Тийм учраас балансын бүтцэд эзлэх эргэлтийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Гэхдээ салбарын балансын үзүүлэлтүүд дундаж үзүүлэлтээсээ тийм ч зөрүүтэй бус байгаа нь ерөнхийдөө хөрөнгө, капиталын бүтэц эдгээр жилүүдэд тогтвортой байсныг судалгааны үр дүн харуулж байна.

2. Төлбөрийн чадварын шинжилгээ

Аливаа бизнесийн байгууллага нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн төлбөрийн хэрэгслээр барагдуулж чадаж байвал төлбөрийн чадвар сайн байгааг илтгэх үзүүлэлт болдог бөгөөд төлбөрийн чадварын үзүүлэлт сайн байх нь санхүүгийн чадавхи сайн байгааг илэрхийлнэ. Хүснэгт №6-аар салбарын төлбөрийн чадварыг тодорхойлох санхүүгийн харьцаануудыг тооцоолон харуулав.

<i>Хүснэгт №6</i>				
Үзүүлэлт	2004	2005	2006	2007
Ажлын капитал(сая.төг)	227,68	114,60	76,55	108,51
Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	0,83	0,55	0,09	1,19
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	2,13	2,15	0,87	2,25
Нөхөлтийн коэффициент	3,41	3,46	1,40	2,87
Z индекс	7,01	13,66	5,87	12,44
Үзүүлэлт	2008	2009	Дундаж	
Ажлын капитал(сая.төг)	(7,23)	(378,51)	23,60	
Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	0,13	0,06	0,47	
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	1,68	1,11	1,70	
Нөхөлтийн коэффициент	4,70	2,08	2,99	
Z индекс	14,43	13,05	11,08	

Дээрх хүснэгтээс харахад салбарын дүнгээр ажлын капиталын хэмжээ жилээс жил буурсан үзүүлэлт гарсан байгаа нь богино хугацаат хөрөнгийн санхүүжилтийг барагдуулах төлбөрийн хэрэгсэл багасаж, эргэлтийн хөрөнгийн багтаамж муудсаныг илэрхийлж байна. Энэ үзүүлэлт 2004-2006 онуудад 113,09-151,13 сая төгрөгөөр буурч байгаад 2008 онд өмнөх оноос 41,7%-аар өссөн үзүүлэлтэй байсан байна. Харин 2008-2009 онуудад энэ үзүүлэлт сөрөг утгатай гарсан байгаа нь салбарын төлбөрийн чадвар буурсныг илэрхийлэх үзүүлэлт болох боловч бусад санхүүгийн харьцаанууд нь зохистой утгатайгаа ойролцоо байгаа нь төлбөрийн чадвар салбарын хувьд тийм ч муу байсан гэх үндэслэл байхгүй юм. Үүнийг түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 1.11, эргэлтийн харьцаа 2.08 байгаа зэргээс харж болох юм. Тиймээс төлбөрийн чадвар буурсан бус харин хөрөнгө, хөрөнгийн санхүүжилтийн бүтэц алдагдсанаас болж ажлын капитал буурсан байна. Нөгөө талаас 2008-2009 онуудад дэлхийн эдийн засгийн хямрал болж улс орны эдийн засаг болоод салбарын санхүүгийн чадавхийн үзүүлэлтэнд сөрөг нөлөө үзүүлсэн байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа 2006, 2008, 2009 онуудад зохистой утгаасаа (зохистой утга 0,2-оос дээш)доогуур тооцоологдсон судалгаа гарсан байгаа нь яаралтай төлбөр барагдуулах хэрэгсэл болох мөнгөн хөрөнгийн хэрэгцээ дутагдалтай байсныг илэрхийлж байна. Энэ

нь тухайн салбарын бүтээгдэхүүн борлуулалт ихэнхдээ дараа тооцоогоор хийгдэж, авлага цуглуулалт тааруу байсантай холбоотой. Харин бусад онуудад энэ үзүүлэлт дундаж үзүүлэлтээсээ дээгүүр байсан байна. Харин түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа болон нөхөлтийн коэффициент салбарын хэмжээнд зохистой утгуудын хэмжээнд хэлбэлзэж байгаа тул төлбөр барагдуулах ойрын болоод хэтийн боломж сайн байгааг илтгэж байна.

Салбарын санхүүгийн хүндрэлийн зэрэглэлийг Альтманы Z индексээр тооцсон үр дүнгээс харахад дундаж үзүүлэлт 11,08 буюу 2,675 гэсэн зохистой үзүүлэлтээс даруй 4 дахин дээгүүр байгаа тул санхүүгийн хувьд хүндрэлд орох магадлал бараг байхгүй гэж хэлж болно. Энэ нь нийт хөрөнгийн 90% орчмыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаатай холбоотой.

3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Төлбөрийн чадварыг үнэлж дүгнэснээр байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох боломж бий болж эдгээр үзүүлэлтийн цогцоор санхүүгийн чадавхийг тодорхойлох үндэс суурь тавигддаг гэж болно. Орхон аймгийн 2004-2009 оны салбарын тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг хүснэгт №6-аар тооцон харууллаа.

Хүснэгт №6

Үзүүлэлт	2004	2005	2006	2007
Бие даалтын коэффициент	0,89	0,91	0,82	0,89
Хараат байдлын коэффициент	1,12	1,11	1,29	1,13
Өрийнхарьцаа	0,12	0,11	0,29	0,13
Гадны капиталын хувийн жин	0,11	0,09	0,18	0,11
Байнгийн капиталын бүтэц	0,01	0,01	0,01	0,01
Гадны капиталын бүтэц	0,20	0,20	0,20	0,20
Зохицуулалтын коэффициент	0,21	0,08	0,23	0,05
Үзүүлэлт	2008	2009	Дундаж	
Бие даалтын коэффициент	0,90	0,86	0,88	
Хараат байдлын коэффициент	1,14	1,19	1,16	
Өрийнхарьцаа	0,14	0,19	0,16	
Гадны капиталын хувийн жин	0,10	0,14	0,12	
Байнгийн капиталын бүтэц	0,00	0,01	0,01	
Гадны капиталын бүтэц	0,20	0,19	0,20	
Зохицуулалтын коэффициент	0,05	0,03	0,11	

Судалгааны үр дүнгээс харахад салбарын бие даах чадвар маш өндөр байгаа нь бие даалтын болоод хараат байдлын коэффициентын дундаж үзүүлэлт болон жил бүрийн ерөнхий динамик хандлагаар нотлогдож байна. Хөрөнгийн 82-91%-ийг өөрийн хөрөнгөөр, 9-18%-ийг гадны капиталаар санхүүжүүлсэн байна. Гадны капиталын бүтцэд урт хугацаат өр төлбөрийн оролцоо 20% байгаа бөгөөд энэ үзүүлэлт 2004-2009

онуудад тогтвортой хадгалагдаж ирсэн нь салбар урт хугацаат санхүүжилтийг татан төвлөрүүлээгүйг илэрхийлж байна. Ерөнхийдөө энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгөө санхүүжүүлж байдаг тул санхүүгийн тогтвортой байдлыг бий болгож байдаг гэхэд болно.

Өрийн харьцаа 1-ээс доош байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа бөгөөд энэ нь өр төлбөрийн оролцоо хөрөнгийн санхүүжилтэнд багахан хувийг буюу дундажаар 16%-ийг эзэлдэг гэдгийг дахин нотлон харуулж байна. Гэхдээ эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх байнгын капиталын оролцоо буюу өөрийн эргэлтийн капитал, түүний зохицуулалтын коэффициент ерөнхийдөө буурах хандлага ажиглагдаж байгаа тул тодорхой хэмжээгээр гадны капиталын оролцоог зохистой хэмжээгээр ашиглаж үйлдвэрлэл, борлуулалтыг тасалдуулалгүй, түргэтгэхийн сацуу эх үүсвэрийн бүтцийг шинэчлэн сайжруулахыг харуулж байна.

4. Хөрөнгө, капиталын ашиглалт, эргэцийн шинжилгээ

Энэ бүлэг үзүүлэлтээр тухайн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагаа нь хэр үр өгөөжтэй бөгөөд хөрөнгө, капиталыг зохистой ашиглан хэрхэн орлого бүтээж буйг үнэлж дүгнэж болдог. Салбарын 2004-2009 оны хөрөнгийн ачаалал, эргэцийн үзүүлэлтийг хүснэгт №7-оор тооцон харуулав.

Хүснэгт №7

Үзүүлэлт	2004	2005	2006	2007
Авлагын эргэц (хоногоор)	9,89	21,60	23,54	22,98
Бараа материалын эргэц (хоногоор)	12,98	17,67	19,37	22,79
Эргэлтийн хөрөнгийнэргэц (хоногоор)	11,64	22,82	26,86	29,97
Нийт хөрөнгийн эргэц (хоногоор)	106,93	269,54	287,40	353,21
Өглөгийнэргэц (хоногоор)	34,49	62,04	72,90	77,35
Нийтхөрөнгийначаалал	1,74	1,09	1,66	0,95
Үндсэнхөрөнгийначаалал	7,94	1,34	109,88	1,11
Өөрийн хөрөнгийн ачаалал	2,02	1,29	2,59	1,14
Үзүүлэлт	2008	2009	Дундаж	
Авлагынэргэц (хоногоор)	0,07	0,06	13,03	
Барааматериалынэргэц (хоногоор)	22,25	20,51	19,26	
Эргэлтийнхөрөнгийнэргэц (хоногоор)	36,58	36,61	27,41	
Нийтхөрөнгийнэргэц (хоногоор)	385,22	424,57	304,48	
Өглөгийнэргэц (хоногоор)	5,22	15,57	44,59	

Нийтхөрөнгийн ачаалал	0,78	0,78	1,17	
Үндсэн хөрөнгийн ачаалал	1,03	0,98	20,38	
Өөрийн хөрөнгийн ачаалал	1,05	0,99	1,51	

Хөрөнгийн ачааллын үзүүлэлтээс харахад нийт хөрөнгийн ачааллын жилийн дундаж өсөлтийн хурд -14,83% байгаа нь нэгж хөрөнгөөс хүртэх борлуулалтын орлогын хэмжээ жил тутам буурч буйг харуулж байна. 2009 оныг 2004 онтой харьцуулахад энэ салбарын нийт хөрөнгийн ачаалал даруй 55%-аар буурсан үр дүн харагдаж байгаа нь сүүлийн жилд хөрөнгийн ашиглалт бага байгааг харуулж байна. Түүнчлэн үндсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн ашиглалтын түвшин жилээс жилд буурах хандлага гарч байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Борлуулалтын орлого жилээс жилд өсөх хандлага бий болж байгаа нь компаниудын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр нотлогдож байгаа боловч салбарын нийт хөрөнгийн болоод эргэлтийн бус хөрөнгө, өөрийн капиталын хувийн жин жил бүр өссөнөөс ачааллын үзүүлэлт буурах нөлөөг бий болгож байна. Өөрөө хэлбэл борлуулалтын орлогын өсөлтөөс хөрөнгийн өсөлтийн хурд илүү байна.

Эргэцийн үзүүлэлтээс харахад авлага цуглуулах дундаж хугацаа 13 хоног, өр төлбөр барагдуулах дундаж хугацаа 45 хоног байгаа бөгөөд үйлдвэрлэлийн цикл дундажаар 32 хоног байна. Эргэлтийн хөрөнгийн эргэц дундажаар 27 хоног байгаа ч сүүлийн жилүүдэд эргэц удаашрах хандлага бий болсон дүр зураг харагдаж байна. Үүнд авлагын эргэц түргэссэн ч бараа материалын эргэц удааширсан нь нөлөөлсөн. Түүнчлэн балансад эзлэх эргэлтийн бус хөрөнгийн хувийн жингийн өсөлтөөс шалтгаалан нийт хөрөнгийн эргэц удааширсан байна. Өглөг, авлагын эргэц түргэсэж байгаа нь салбарын хэмжээнд бодлогын түвшинд тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласан нь эерэг нөлөөлөл үзүүлсэн байна. Тухайлбал, эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, нэг худалдан авагчтай загвар гэх зэрэг арга хэмжээнүүдийг дурьдаж болох юм.

Авлагын эргэц хурдсаж байгаа нь салбарын борлуулалтыг түргэтгэж, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх бол өглөгийн эргэц хурдассан нь санхүүгийн хувьд бие даах чадварыг улам бүр дээшлүүлэх бөгөөд ингэснээр салбарын санхүүгийн чадавхи дээшлэх боломжийг олгож байна.

5. Ашигт ажиллагааны шинжилгээ

Оруулсан хөрөнгөөсөө хэр зэрэг өгөөж хүртэж буйг тодорхойлох үндсэн үзүүлэлт нь ашигт ажиллагааны үзүүлэлтүүд байдаг бөгөөд эдгээрийг хүснэгт №8-аар тооцоолон харуулав.

Хүснэгт №8

Үзүүлэлт	2004	2005	2006	2007	2008	2009	Дундаж
Нийт ашгийн түвшин	0,56	0,47	0,55	0,54	0,51	0,39	0,50
Хөрөнгийн ашигт ажиллагаа	(0,39)	(0,14)	(0,45)	(0,02)	(0,02)	(0,04)	(0,18)
Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	(0,42)	(0,15)	(0,89)	(0,02)	(0,02)	(0,05)	(0,26)
Нийт хөрөнгийн өгөөж	(0,39)	(0,14)	(0,45)	(0,02)	(0,02)	(0,04)	(0,18)
Оруулсан капиталын ашигт ажиллагаа	6,88	0,45	109,03	0,23	0,32	0,38	19,55
Өөрийн капиталын өгөөж	(0,42)	(0,15)	(0,89)	(0,02)	(0,02)	(0,05)	(0,26)
Борлуулалтын өгөөж	0,03	(0,07)	(0,02)	(0,01)	0,03	(0,10)	(0,03)

Судалгааны тооцооллоос харахад нийт ашгийн түвшний үзүүлэлтээр борлуулалтын орлогын нэг төгрөг тутмаас дундажаар 50₮-ийн ашиг олж байгаа нь харагдаж байна. Энэ үзүүлэлт нь 2004-2008 онуудад ерөнхийдөө тогтвортой байсан бол 2009 онд өмнөх оноосоо 23,5%-аар буурсан байна. Гэхдээ энэ нийт ашгийн түвшний хувьд тийм ч доогуур үзүүлэлт биш юм. Гэхдээ салбарын хувьд нийт ашгийн түвшний үзүүлэлтээр тооцсон судалгааны үр дүн эерэг гарсан ч бусад үзүүлэлтийн ашигт ажиллагаа, өгөөжийн үзүүлэлтүүд сөрөг утгатай гарсан нь харагдаж байна. Тухайлбал, борлуулалтын өгөөж дундажаар -0,03 гарсан нь салбарын үйл ажиллагааны зардал өндөр байдгийг харуулж байна. Үйл ажиллагааны зардлыг өсгөх үзүүлэлт нь элэгдлийн зардал байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Учир нь тухайн салбарын хувьд эргэлтийн бус хөрөнгө бараг хөрөнгийн 90%-ийг бүрдүүлж буй тул элэгдлийн зардал тайлант жилүүдэд их гардаг болохыг нотлох юм. Салбарын хувьд цэвэр ашгаас хүртэх хөрөнгө, өөрийн хөрөнгө зэргийн ашигт ажиллагаа байхгүй байна. Иймд ашигт ажиллагааг дээшлүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд ийм бодлогыг орон нутгийн засаг захиргаа болоод байгууллагуудын зүгээс төдийгүй улсаас авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дүгнэлт

Орхон аймгийн цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт ба түгээлт, усан хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын 2004-2009 оны санхүүгийн тайланд санхүүгийн чадавхийг тодорхойлох санхүүгийн харьцаануудаар шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнд:

1. Салбарын хөрөнгийн бүтцийн дунджаар 88% орчмыг эргэлтийн бус хөрөнгө, хөрөнгийн санхүүжилтийн мөн хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Энэ нь салбарын хөрөнгө, капиталын бүтэц оновчтой бус байгааг харуулж байна.

2. Салбарын санхүүгийн чадавхийг тодорхойлох гол үзүүлэлтүүд болох төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой, зохистой түвшинд байна.

3. Салбарын хөрөнгийн ашиглалтын үзүүлэлтэнд буурах дүр зураг гарсан байгаа нь хөрөнгийн ашиглалтыг эрчимжүүлэх бодлого авч хэрэгжүүлэхийг сануулж байна. Авлага, өглөгийн эргэц түргэссэнээс борлуулалт болон худалдан авалтыг түргэтгэсэн ч бараа материалын эргэц удааширснаас хөрөнгийн эргэцийг удаашруулсан байна.

4. Салбарын оруулсан хөрөнгийн өгөөжийн үр дүн 2004-2009 онуудад сөрөг үзүүлэлттэй байгаа нь тухайн салбарт алдагдал ихээр хуримтлагдсаныг харуулж байна. Мөн түүнчлэн үйл ажиллагааны зардал их гардаг гэсэн дүгнэлтүүд гарч байна.

Салбарын санхүү-эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд доорх асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүнд:

1. Хөрөнгө, хөрөнгийн санхүүжилтийн бүтцийн оновчтой харьцааг тодорхойлох;

Байгууллагын үйл ажиллагаа өргөжихийн хэрээр гадны капиталын оролцоо нэмэгдэж байдаг бөгөөд түүнийг оновчтойгоор удирдан үр өгөөжтэй ашиглах нь компаний менежментийн чухал асуудлын нэг болно. Салбарын хувьд сүүлийн 6 жилийн дундаж үзүүлэлтээр эргэлтийн хөрөнгийн 92,8%-ийг богино хугацаат өр төлбөрөөр, 7,2%-ийг урт хугацаат өр төлбөрөөр санхүүжүүлсэн бол эргэлтийн бус хөрөнгийн 0,2%-ийг урт хугацаат өр төлбөрөөр, 99,8%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Бизнесийн үйл ажиллагааг гадаад санхүүжилтээр хангах бодит шаардлага, нөгөө талаас хөрөнгийн хөрвөх болон төлбөрийн чадварын тогтвортой хэвийн түвшин зэргийг харгалзан тооцоолсон ОХУ-ын судлаач Г.В.Савицкаягийн санал болгосноор салбарын 2004-2009 оны хөрөнгийн санхүүжилтийн дундаж үзүүлэлтийг тооцоолоход:

Санхүүжилтийн эх үүсвэр	Санхүүжилтийн бүтэц			Салбарын дундаж
	А (шинэлэг)	В (дунд зэрэг)	С (хуучинсаг)	
БХӨ	30	30	15	10,97
УХӨ	31	15,5	4	0,96
ӨК	39	54,5	81	88,07

Аймгийн салбарын үзүүлэлт нь судалгааны үр дүнгээс харахад хуучинсаг бүтэцтэй байна. Тиймээс хөрөнгийн бүтцийн оновчтой хэмжээг боломжит хамгийн бага түвшингээр тооцвол, эргэлтийн хөрөнгийн балансад эзлэх хувийн жин 16,16%, эргэлтийн бус хөрөнгийнх 83,84% байж болохоор байна.

Балансын бүтцийг оновчтой хэмжээнд тогтоохдоо салбарын хувьд хуучирсан, үнэ цэнэ буурсан, ашиглалтын хугацаа дууссан эргэлтийн бус хөрөнгүүдийг түргэвчилсэн аргаар элэгдүүлэх бодлого баримтлах, хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрч хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж байх, дахин үнэлгээ хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

2. Төлбөрийн чадварын үзүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалах;

Балансын бүтцийг сайжруулж, ажлын капитал болон өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлсээр салбарын ажлын капитал эерэг (эргэлтийн хөрөнгийн боломжит хамгийн бага утга (16,16%)-аас богино хугацаат өр төлбөрийн боломжит хамгийн бага утга (15%)-ыг хассан утга) утгаа хадгалсаар байх бөгөөд ингэснээр нөхөлтийн коэффициент хамгийн багадаа $1,08(16,16\%/15\%)$ байх нь судалгааны үр дүнгээс гарлаа. Энэ нь богино хугацаанд өр төлөх өр төлбөрөө барагдуулахуйц төлбөрийн хэрэгсэл хүрэлцэхүйц хэмжээнд байгааг харуулж байна. Иймээс балансын бүтцийг сайжруулж чадсанаар төлбөрийн чадварыг тогтвортой түвшинд хадгалж чадна.

3. Салбарын өр, авлагын менежментийг сайжруулах;

Авлага цуглуулалт болон өр барагдуулалтын хугацаатүргэсэх хандлага Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн судалгааны үр дүнгээс харагдаж байгаа ч макро түвшинд улсын нийт дүнгээр салбарын өр, авлагын хэмжээ өссөн байна. Тиймээс өглөг, авлагын менежментийг боловсронгуй болгохын тулд:

- Авлага, өглөгийн насжилтийн судалгаа хийх, найдваргүй авлагын нөөц байгуулж байх;
 - Хямд өртөгтэй, урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэрээр эрсдэл ихтэй зарим богино хугацаат өр төлбөрийг барагдуулах;
 - Борлуулалтын бодлогод урьдчилан орлого төвлөрүүлэлтийн технологи нэвтрүүлэх;

- Материалын төлөвлөлт, аюулгүйн нөөц, захиалгын оновчтой тоо хэмжээний загварыг ашиглаж, худалдан авалтын өглөгийн барагдуулалтыг төлөвлөж байх;

- Улсын төсөв, гадаадын зээл тусламж, орон нутаг болон байгууллагын өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор хийх, салбарын хөгжилд төр хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх

4. Салбарын болон бүсийн хэмжээнд удирдлагын оновчтой бүтэц бий болгох, зардал бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, түгээлт, усан хангамжийн салбарыг удирдлагын хувьд оновчтойгоор зохион байгуулж, улмаар салбарын зардлыг бууруулж, ашигт ажиллагааг дээшлүүлэхийн тулд доорх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүнд:

- Бүс нутгийн хамтын ажиллагаа, хөрш орнуудын салбарын бодлоготой уялдуулан хөгжүүлэх;
- Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгаарласан шинэ дэд бүтцийн систем, технологийг нэвтрүүлэх, өнөөгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Салбарын эрх зүйн орчныг сайжруулах;
- Салбарын бодлогыг ул үндэслэл, суурь судалгаатайгаар боловсруулж, үнэлэлт дүгнэлт өгөх
- Хуучирсан хөрөнгө, техник тоног төхөөрөмжийг системтэйгээр шинэчлэх зэрэг болно.

Салбарын хувьд бүтээгдэхүүн үйлдвэрлэлт болон борлуулалтын хэмжээ жил бүр өссөн, засгийн газар болон аж ахуйн нэгж байгууллагуудын зүгээс салбарын макро болон микро орчний түвшинд бөөний худалдааны сүлжээнд шинэ технологи нэвтрүүлсэн, эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт хийсэн, шинэ техник технологи нэвтрүүлсэн, салбарын алдагдлыг бууруулахад чиглэсэн олон төслүүдийг хэрэгжүүлсэн зэрэг тодорхой үр дүнтэй ажлуудыг зохион байгуулснаар салбарын санхүүгийн чадавхи сэргэх хандлага бий болж байна.

Ном зүй:

- 1 Моломжамц.Д “Санхүүгийн шинжилгээ” Эрдэнэт, Дархан, Улаанбаатар 2000 он
- 2 Сайнжаргал.Б “Санхүүгийн тайлангийн шинжилгээ” Улаанбаатар.1999 он
- 3 Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ 2009 он
- 4 МУИС.Эдийн засгийн сургууль “Монгол улс зах зээлд” Улаанбаатар. 2007 он
- 5 МУИС.Эдийн засгийн сургууль “Шилжилтийн эдийн засагтай орнуудад тулгарч буй асуудлууд” Улаанбаатар. 2007 он
- 6 Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс “Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжил (2004-2008)”. Эрдэнэт хот. 2009 он